



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 05 сарын 18 өдөр

Дугаар Д/105

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн 13 дугаар
сургуулийн данс бүртгэлд хөрөнгө
бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 2,199,900 /хоёр сая нэг зуун ерэн есөн мянга есөн зуу/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Баянгол дүүргийн 13 дугаар сургууль (С.Байгалмаа)-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн 13 дугаар сургууль (С.Байгалмаа)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М. БАЯРАА

Тушаал-2021

115050000391